Орлогын талаар Орлогыг 2022 онд нийт орлогыг 547,2 сая төгрөгөөр төлвөлсөн боловч гүйцэтгэлээр 172,1 сая төгрөг болж буурсан нь 2022 оны 06 сарын 06 өдрөөс Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв ТӨААТҮГ болон өөрчлөгдөн зохион байгуулсан ч Биеийн тамир спортын улсын хороонд шигшээ багийн дотоод гадаадын бэлтгэлийн зардал тусгагдаагүй улмаас тамирчид байрлан бэлтгэл хийх боломж бүрдээгүйд оршино.

Зардлын талаар 2022 онд 547,1 сая төгрөгөөр төлвөлсөн боловч гүйцэтгэлээр 215,1 сая төгрөг болсон байна. Уг зардал нь Ажилчдын цалин, Ашиглалтын зардал, Тамирчдын бэлтгэл сургалтыг хангах олон улсын тэмцээн уралдаанд авч явах 5,6мм сум худалдан авах зэрэг зардлууд орж байна

Авлагын талаар 2018 онд Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн харьяа “Техник спортын төв” ТББ-аас дутсан 24.6 сая төгрөгийн хөрөнгөнд тайлбар өгөх талаар БХТН-ийн харьяа “Техник спортын төв”-д удаа дараа албан бичиг явуулсан боловч ямар нэгэн хариу өгөөгүй тул 2018 оны 12-р сарын 10-нд ХУД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гомдол гарган шийдвэрлүүлэхээр өгөөд одоог хүртэл эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Уг маргаан нь Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхим шүүгчийн бүрэлдэхүүн байхгүй гэдэг шалтгаанаар шүүгчид хувиарлагдахгүй гацсан байдалтай байсаар 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдөр талуудыг байлцуулан онлайнаар хуралдаж хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хянан хэлэлцээд Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж хариуцагчийн гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн.

Иймд одоогийн байдлаар уг хэрэг маргаан Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд буцаагдаж тус шүүхэд шинээр нотлох баримт гаргаж хэргийг дахин шийдвэрлүүлэх ажиллагаа хуулийн дагуу хийгдэхээр болсон.

Өглөгийн талаар 2022 онд 434,2 сая болгон бууруулахаар төлөвлөсөн боловч 733,7 сая төгрөгийн өглөгтэй байна. Энэ нь 2019 оны их засварын ажлын үеийн сул зогсолтын байдал, COVID-19 цар тахлын улмаас Монгол Улсад 2020 оны 01 дүгээр сараас эхлэн бүх төрлийн спортын сургалт, тэмцээн уралдааныг хориглосон улсын онцгой комиссын шийдвэрүүд үе шаттайгаар хэрэгжиж байгууллагын сургалтын болон бусад үйл ажиллагаа доголдож орлого зогсонги байдалтай болсноор ажилчдын цалин, ндш, татвар, дулаан, цахилгаан, газрын төлбөр, шинээр үүсгэн байгуулсан тамирчин зоогийн газар, зочид буудлын тавилга эд хогшил бусад хэрэгслүүдийг зээлээр худалдан авсан төлбөрийн өглөгүүд хуримтлагдсан мөн 2 байгууллага нэгдэж Булганы спорт баазын 85,3 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн болно.

Танилцуулга бичсэн ня-бо:



Э.Мөнхболд

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНА-2023/47/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2023 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Аудитор: П.Батцэцэг
Утас: 261740 Цахим хаяг: battsetsegp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Материаллаг байдал	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 Албан шаардлага	12
5.2 Зөвлөмж	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ҮШББСТ	Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН БЭЛТГЭЛ,
СУРГАЛТЫН ТӨВ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.НАРАН-ИДЭР ТАНАА

2023.03.15

07/558

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийж баталгаажуулаагүй, 467.7 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ"12.2.1"Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл: Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа 70.1/ үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/; 70.2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 52 дугаар

Z:\Yawsan_Bichigi\2023\0315 SNAG-54.Docx

0001051025

тогтоолоор Булган аймгийн Хангал суман дахь Спортын бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГГазар, Техник спортын төв ТӨААТҮГ-ыг нэгтгэн Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр гарч, байгууллагын бүтэц орон тоог ТӨБЗГ-ын 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 269 дүгээр тогтоолоор баталсантай холбоотойгоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг шинэчлэн батлуулж ажиллаагүй байна.

Аудитын гол асуудал

Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төв ТӨААТҮГ-г “Ковид-19” цар тахал болон 2019-2020 онд үндсэн барилга байгууламжид хийсэн их засварын ажлын нөхцөл байдалтай холбоотой сул зогссоны улмаас санхүүжилтийн эх үүсвэр хомсдож, санхүүгийн тайланд ажилчдын гарт олгох цалин хөлсний 178.1 сая, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн 215.3 сая, газрын төлбөрийн 102.0 сая, ашиглалтын зардлын 96.9 сая, бусад өр төлбөр 141.4 сая, нийт 733.7 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр үүсч, барагдуулах боломжгүй байдалд хүрсэн тул байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/937 дугаар захирамжаар тус байгууллагад 23,787 мкв талбайтай 7 жилийн хугацаатай эзэмшихээр олгосон газрын гэрчилгээний хугацаа 2022 онд дууссан боловч газрын төлбөрийн хуримтлагдсан өр төлбөр 102.0 сая төгрөгт хүрч, газрын гэрчилгээг шинэчлэн гаргуулаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		394,523.48
1.1.2	Дансны авлага		24,649,298.99
1.1.6	Бараа материал		110,285,272.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн		135,329,095.10
1.2.1	Үндсэн хөрөнгө		1,564,653,506.72
1.2.2	Биет бус хөрөнгө		1,460,833.38
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,566,114,340.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1,701,443,435.20
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1.1.1	Дансны өглөг		525,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг		178,143,054.52
2.1.1.3	Татварын өр		157,487,011.15
2.1.1.4	НДШ - ийн өглөг		159,852,475.17
2.1.1.5	Богино хугацаат зээл		99,386,608.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		138,389,187.20
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		733,783,336.04
2.2	Өр төлбөрийн нийт дүн		733,783,336.04
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн		2,020,478,530.99
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		817,900,316.08
2.3.9	Хуримтлагдсан ашиг		(1,870,718,747.91)
2.3.11	Эздийн өмчийн дүн		967,660,099.16
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		1,701,443,435.20

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 1-р сарын 1	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		48,045,600.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)		48,045,600.00
8	Бусад орлого		172,858,830.57
9	Борлуулалт, маркетингийн зардал		78,405,450.31
10	Ерөнхий ба удирдлагын зардал		334,629,681.51
12	Бусад зардал		31,125,141.23
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		17,546.85
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(223,238,295.63)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)		(223,238,295.63)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		(223,238,295.63)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
26	Бусад олз (гарз)		
27	Орлогын нийт дүн		(223,238,295.63)
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,020,478,530.99	817,900,316.08	(1,647,480,452.28)	1,190,898,394.79
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл	2,020,478,530.99	817,900,316.08	(1,647,480,452.28)	1,190,898,394.79
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(223,238,295.63)	(223,238,295.63)
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,020,478,530.99	817,900,316.08	(1,870,718,747.91)	967,660,099.16

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 1-р сарын 1	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		172,171,977.46
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		39,345,600.00
	Бусад мөнгөн орлого		132,826,377.46
1.2	Мөнгөн зарлага (-)		215,130,523.07
	Ажиллагчдад төлсөн		39,918,295.00
	Ашиглалтын зардалд төлсөн		25,464,742.24
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		3,618,603.80
	Татварын байгууллагад төлсөн		774,618.00
	Даатгалын төлбөрт төлсөн		6,983,806.50
	Бусад мөнгөн зарлага		138,370,457.53
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(42,958,545.61)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		95,464,200.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		95,464,200.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		54,000,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		54,000,000.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		41,464,200.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		(1,494,345.61)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,888,869.09
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		394,523.48

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Булган аймгийн Хангал суман дахь Спортын бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ, Техник спортын төв ТӨААТҮГ-ыг нэгтгэн Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ газар болгон өөрчлөн зохион байгуулах шийдвэр гарсан байна.

Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын эрхэм зорилго нь биеийн тамир спортыг олон нийтэд сурталчлан таниулах, сургалт дасгалжуулалт хийлгэх, тэмцээн уралдаан зохион байгуулах, дотоодын болон олон улс, тив дэлхийд нэрээ дуурсгасан үндэсний шигшээ багийн залгамж халааг тасралтгүй төрүүлэн гаргах зэргээр нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь Монгол Улс олон улсын жишигт нийцсэн Үндэсний шигшээ баг болон анхлан суралцагч тамирчид, иргэд олон нийтэд хүртээмжтэйгээр спортын комплекс бүхий цогцолбор баазыг Булган аймгийн Хангал сумын нутаг дахь “Олимп” бэлтгэлийн баазыг түшиглэн барьж байгуулахаар ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын дүрэмд Бэлтгэл, сургалтын төв нь биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж үндэсний шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлд спортын шинжлэх ухааны үндэслэлтэй сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагааг цогц хэлбэрээр явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж тодорхойлжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанаар Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ыг Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-т нэгтгэн зохион байгуулах 243 дугаар тогтоол батлагдаж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Тус байгууллага нь Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль, Биеийн тамир спортын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, татварын ерөнхий хууль болон түүнтэй дагалдан гарсан багц хуулиуд, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох дүрэм зааврын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдан зохион байгуулдаг. Тус үйлдвэрийн газрын дүрмийг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан боловч тайлант хугацаанд дүрмийн зарим заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 269 дүгээр тогтоолоор тус байгууллагын бүтэц орон тоог 3 албатай, нийт 41 хүртэл орон тоотой байхаар баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Сангийн сайдын 2022 оны “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 дугаар тушаал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны “Журам батлах тухай - Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам” 65 дугаар тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Биеийн тамир, спортын улсын хорооны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгээгүй, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын дагуу бэлтгэж ирүүлсэн байна.

Тайлант оны 6 сард 2 байгууллага нэгтгэгдсэн тул эхний үлдэгдэл байхгүй.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		394.5	
Авлага		24,649.3	
Бараа материал		110,285.3	
Үндсэн хөрөнгө		1,566,114.3	
Нийт хөрөнгийн дүн		1,701,443.4	
Богино хугацаат өглөг		733,783.3	
Эздийн өмч		967,660.1	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		1,701,443.4	

Батлан хамгаалахад туслах нийгэмлэг ТББ-аас нэхэмжлэлтэй шүүхийн шатанд шийдвэрлээгүй 24.6 сая төгрөгийн авлагын дансны үлдэгдэл байна. Нэхэмжлэлийг Монгол Улсын Дээд шүүхийн 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн дугаар 001/ХТ2021/01276 тогтоолоор Хан-Уул дүүргийн анхан шатны шүүхэд буцаасан байна.

Авто тээврийн хэрэгсэл дансны үлдэгдэл нэмэгдсэн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор балансаас балансад 65.0 сая төгрөгийн өртөгтэй автомашин хүлээн авсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 733.7 сая төгрөг болсон нь Хангал суман дахь Спортын бэлтгэлийн төвөөс шилжиж ирсэн 85.4 сая төгрөгийн өр, ХХОАТ-ын 55.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 159.8 сая төгрөг, газрын төлбөрийн 102.0 сая төгрөг, цалингийн 178.1 сая төгрөг, ашиглалтын зардлын 96.9 сая төгрөг, бусад хувь хүн байгууллагад төлөх өр төлбөр 56.4 сая төгрөг тус тус бүртгэснээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох 20 дугаар зүйлийн 20.1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны дагуу Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 649 дүгээр тогтоолоор Техник спортын төв ТӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 547.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 547.1 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 52 дугаар тогтоолоор тус байгууллага өөрчлөн зохион байгуулагдсаны улмаас шинэчилсэн төлөвлөгөөг батлуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн шалгагдагч байгууллагад өдөр тутмын үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор П.Батцэцэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Болор-Эрдэнэ, аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн А-1/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 361.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын дагуу бичиг хэрэг, албан томилолт, гадаад сургалт, арга хэмжээний зардал, зочин төлөөлөгч бэлэг дурсгалын зүйл, ном авах зэрэг зардлыг 4.9 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд нийт 117 мэдээлэл оруулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож 109 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Техник спортын төв ТӨААТҮГ газар түүвэрт хамрагдаж, Булган аймгийн Хангал суманд дахь Спортын бэлтгэлийн төвийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 15.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 акт, 8.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 6.6 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснийг 77 хувийг хэрэгжүүлж ажилласан байна. Хэрэгжилтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	0.3	1	0.3	-	-	100
Албан шаардлага	2	8.5	1	8.5	1	-	50
Зөвлөмж	5	6.6	4	6.6	1	-	80
Нийт дүн	8	15.4	6	15.4	2	-	76

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Булган аймгийн Хангал суман дахь Олимп бэлтгэлийн баазын тамирчдын бэлтгэл хангуулах зориулалт бүхий газрын гэрчилгээ гараагүй, санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг болон үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудалд нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлж, дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар бараа материалын тодруулгын тайлан, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 64.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж баталгаажуулав.

Аудитаар нийт 470.7 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 467.7 сая төгрөгийн алдааг засах 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 470.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшингээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан 110.2 сая төгрөгийн бараа материал, 1,564.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-т "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/; 70.2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг цаглабарт хугацаанд хийж гүйцэтгэн, үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар албан шаардлага хүргүүлэх.

2. 2,893.9 мянган төгрөгийн шатахууны зардлыг хэмнэж ажиллаагүй, зарцуулалтыг бараа материалын тайлангаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн тооцооны замын хуудсыг тухай бүр хөтөлж, бараа материалын тайланд тусгах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Богино хугацаат өр төлбөр дансанд ашиглалтын зардал, газрын төлбөр, цалин, нийгмийн даатгалын өр төлбөр зэрэг 733,022.7 мянган төгрөг бүртгэгдсэнээс 476,925.6 мянган

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалттай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, өр төлбөрийг барагдуулж ажиллах.

2. НБББББ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 52 дугаар тогтоолоор Булган аймгийн Хангал суман дахь Спортын бэлтгэл, сургалтын төв, Техник спортын төвүүдийг нэгтгэн Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГазар болгон өөрчлөн зохион байгуулсан боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон НБББББ-ийг шинэчлэн боловсруулж, батлаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.3-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүү, бүртгэлийн ажилтнууд нэмэлт зардал гаргахгүйгээр байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, стандарт болон хууль, тогтоомжид нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, захирлаар батлуулан, мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

3. Үндсэн хөрөнгийн газрын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/937 дугаар захирамжаар 23787 мкв газрыг 7 жилийн хугацаатай олгосон гэрчилгээний хугацаа 2022 онд дууссан байна. Тухайн байгууллагын нэр дээр газрын гэрчилгээг шинэчлэн гаргуулж ажиллаагүй байгаа нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын хавсралт "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгөтэй холбоотой хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулж, газрын шинэчилсэн гэрчилгээг гаргуулах.

4. Үндсэн хөрөнгийн тээврийн хэрэгслийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

ТӨБЗГ-ын 2022 оны 462 дугаар тогтоолоор тус байгууллагад хүлээлгэн өгсөн 48,750.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий Toyota.Hiace маркийн 5650УНУ дугаартай автомашины Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээг өөрийн байгууллагын нэр дээр шилжүүлэн аваагүй нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам", ТӨБЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/120 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлэн гаргуулах.

5. Үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй, цаашид ашиглах боломжтой 66 нэр төрлийн 171,573.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, цаашид ашиглах боломжгүй 63,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй Экс terra тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн дансанд дансанд 94 ширхэг 24,035.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй, элэгдэл байгуулахад тохиромжгүй бараа материалын шинжтэй хөрөнгө, тавилга эд хогшлыг тус тус ангилал зөрүүлж бүртгэсэн байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6 дугаар зүйлд "Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах", 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох", ТӨБЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/120 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө, тээврийн хэрэгсэл, бараа материалын ангиллыг буруу тодорхойлсон, нэршил оновчгүй хөрөнгийн жагсаалтыг гарган, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн холбогдох эрх бүхий байгууллагад саналаа хүргүүлж, зохих шийдвэрийг гаргуулан өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж ажиллах.

6. Санхүүгийн тайлангийн тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайланг батлагдсан маягт аргачлалын дагуу иж бүрэн толиулаагүй, хуулийн хугацааг 10 хоног хоцроож ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг хуульд заасан цаглабарт хугацаанд иж бүрэн толилуулгатай ирүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТӨВ ТӨААТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шатахууны 2,893,900.00 төгрөгийн зарцуулалтыг хэмнээгүй, бараа материалын тайлангаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Нхэн шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууны зардлыг бараа материалын тайланд тусгаж, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтөлж хэвшүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын захирал Б.Наран-Идэр, Нягтлан бодогч Э.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ГҮНЖИДМАА

АУДИТОР

П.БАТЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264251

Z:\Alban Shaardlaga\2023\0315 SMAG-21.Docx

0001080911



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТЫН АГЫН ГЭР

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан 110,285.272.63 төгрөгийн бараа материал, 1,564,653,506.76 төгрөгийн төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгөд жилийн эцсийн тооллого хийж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын эгцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-т "Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1-т "үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа", 70.2-т "түүхий эд, материал, туйш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв ТӨААТҮГ-ын захирал Б.Наран-Идэр, Нягтлан бодогч Э.Мөнхболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Г.ГҮНЖИДМАА

П.БАТЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264237

Z:\Alban Shaardlaga\2023\0315 SNAG-21.Docx

0001080908